



НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 02 сарын 17 өдөр

Дугаар А/54

Улаанбаатар хот


「Сүхбаатар дүүргийн Боловсролын хэлтсийн」
данс бүртгэлээс тээврийн хэрэгсэл хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/61 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ашиглалтын шаардлага хангахгүй болж, засаж сэлбэх нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тогтоогдож, сэлбэгийн буюу хоёрдогч түүхий эдийн зориулалтаар татан төвлөрүүлж худалдахаар шийдвэрлэгдсэн 7,500,000 (долоон сая таван зуун мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан тээврийн хэрэгслийг акталж, данс бүртгэлээсээ хасахыг Сүхбаатар дүүргийн Боловсролын хэлтэс (Д.Адъяасүрэн)-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй тээврийн хэрэгслийг Нийслэлийн Өмчийн харилцааны газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийх, тээврийн хэрэгслийн гэрчилгээ, улсын дугаарыг хураан авч, авто тээврийн улсын бүртгэл болон татварын бүртгэлээс хасуулахыг Сүхбаатар дүүргийн Боловсролын хэлтэс (Д.Адъяасүрэн)-т үүрэг болгосугай.


3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг үнэлж, худалдан борлуулах ажлыг зохион байгуулж ажиллахыг Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс (Б.Батбаяр)-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д тус тус даалгасугай



ДАРГА

М. БАЯРАА

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын
2022 оны 02 сарын 19 -ны өдрийн
... А/54 ... тушаалын хавсралт



СЭЛБЭГИЙН БУЮУ ХОЁРДОГЧ ТҮҮХИЙ ЭДИЙН ЗОРИУЛАЛТААР ТАТАН ТӨВЛӨРҮҮЛЖ
ХУДАЛДАХ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЖАГСААЛТ

/төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Автомашин марк, улсын дугаар	Үйлдвэрлэсэн/ Монголд ашиглаж эхэлсэн он	Зориулалт, аль улсад үйлдвэрлэсэн, өнгө	Арлын дугаар	Нийт гүйлт /км/	Балансын үнэ	Эвдрэл гэмтэл
1	Сүхбаатар дүүргийн Боловсролын хэлтэс	Тоёота марк-II 24-67 УНЗ	1997/2007	Суудал ЯПОН Цагаан	GX1006051604	-	7,500,000	Техникийн комиссын дүгнэлтээр тээврийн хэрэгсэлд тавигдах техникийн шаардлага хангахгүй, үйлдвэрлэгдсэнээс хойш 10-аас дээш жил ашиглагдсан тул акталж данснаас хасах.
нийт							7,500,000	